

## 1. SCOPE OF SERVICES AND GOODS

---

### 1.1 Overall purpose:

On 9 May 2017, the Khanbogd soum administration, Khanbogd soum herders, and Oyu Tolgoi company jointly entered into two agreements (Agreement #1 and Agreement #2, together, the Agreements) as the final stage in the resolution of two complaints lodged by Khanbogd soum group of herders to the IFC Compliance Advisory Ombudsman (CAO) in 2012 – 2013 (the Complaints).

Under these two agreements, the parties mutually agreed an action plan, confirming solutions and actions, timeframes, implementation criteria and responsible parties for resolving the Complaints. Since the signing of the Agreements, the Parties have ensured implementation of the Agreements, maintaining mutual respect and support, as stated in Article 5.1 of each of the Agreements.

As agreed with all parties, the Agreements would cease and be terminated upon completion of all actions and works, specified in their appendices.

The TPC discusses and oversees the implementation and monitoring of action items specified in the Agreements. At a TPC meeting held in May 2019, it was agreed that an independent review on the implementation of the Agreements should be conducted. Conditions and requirements for the works to be completed by the independent review team have been defined in this Terms of Reference.

### 1.2 Scope of Work:

Primary data collection activities will include but are not limited to the following:

- Group and individual interviews with TPC members
- Interviews with local soum officials
- Herder household group meetings and interviews
- Interviews and meetings with Company employees
- Others by agreement with the TPC

During the independent review, the following documents should be referenced:

- Herders' Complaints Resolution Agreement #1 and Agreement #2 and their appendixes
- TPC Rules (2017, 2019)
- Minutes of the TPC meetings, where the agreement implementation status was reviewed and evaluated
- TPC reports, joint statements and other official documents (including Multi-Disciplinary Team reports, 2016)
- Official data and statistics  
[TECHNICAL SPECIFICATIONS] \*

Na

## 1. SITE(S) AND WORK LOCATION

---

The Services and Goods are required or will be performed at the following Site(s):

The independent review team will work in the Khanbogd soum, Umnugobi aimag – Mongolia.

## 2. STANDARDS AND SPECIFICATIONS

---

- The independent review methodology, detailed action plan and timeframe considering any impact of COVID restrictions
- Project leader's profile, including a detailed career biography and evidence of experience on similar projects
- Names and detailed biographies for each of the research team members
- Detailed budget breakdown (including professional fees, travel, accommodation, translation costs, etc.)
- Proposals will be prepared in 10 pages as an indicative length.
- Proposals will be prepared and submitted in WORD format in English and Mongolian.

## 3. SUPPLIER'S PERSONNEL SKILLSET

---

The number and names of the Personnel required to provide the Services under this SOW will be as follows:

- The independent review team will consist of 2-3 appropriately qualified and experienced reviewers, with expertise in sociology, micro-economics, and animal husbandry.
- The reviewers should have relevant knowledge, skills and experience in Mongolia or other similar countries and should demonstrate experience and expertise in the implementation of review and audit methodologies.
- Experience in regional development and mining impacts is also essential, while experience with herders and Mongolia's mining sector would be an advantage.
- The review team is obliged to work independently, in accordance with the relevant laws and standards, and with a highly professional code ethics.

## 4. SUPPLY TIMETABLE

---

The Supply Timetable for the Services and Goods under this SOW will be as follows:

- The independent review be carried out within 8 weeks from the date of signing the Contract for Work.
- The independent review draft report will be presented in person and submitted one week prior to the briefing meeting.
- The independent review report will be in WORD format in English and Mongolian.

Due date	Major Task	Responsible
Week 1	Recruit independent organization and approval by End-User	Contractor
Week 2	Work preparations	Contractor
Week 2-5	Actual independent review process	Contractor
Week 5	Prepare final report	Contractor
Week 6	Submit final report files	Contractor
Week 7	Hand-over to customer, brief meeting	Contractor / End-User
Week 8	Receive any compliant or required re-works	Contractor

**5. REQUIRED TRAININGS**

---

What Trainings are required to Supplier?

**OT Induction**

**OT Hazard Identification**

**6. SPECIAL CONDITION**

---

Are there any special conditions? OT General Term and Condition change needed?

## 1.АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

---

### 1.1 Ерөнхий зорилго:

Ханбогд сумын Гурван талт зөвлөлд оролцогч талууд болох Ханбогд сумын засаг захиргаа, Ханбогд сумын малчид, “Оюу толгой” компани хамтран 2017 оны 5 дугаар сарын 9-нд Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээг байгуулсан. Энэ хоёр гэрээ нь 2012-2013 онд Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмэний газарт<sup>1</sup> (Омбудсмэний газар) Ханбогд сумын хэсэг малчдын гаргасан гомдлуудыг барагдуулах шийдэл, хийх ажлууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хариуцах талыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт харилцан тохирч байгуулсан гэрээ юм. Гэрээг баталгаажуулсан цагаас эхлэн өнгөрсөн гурван жилийн хугацаанд талууд гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, Гэрээ 1-ийн 5 дугаар зүйлийн 1-т зааснаар Талууд гэрээний хэрэгжилтийг хангахдаа харилцан хүндэтгэлтэй хандаж, дэмжиж ажиллаж байна.

Малчдын гомдол барагдуулах хоёр ба гэрээнд заасан бүх ажлыг бүрэн хэрэгжүүлснээр Гэрээ дуусгавар болсонд тооцохоор тохирсон.

Гэрээнд заасан үйл ажиллагаа бүрийн хэрэгжилтийн явцыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2019 онд болсон ГТЗ-ийн хурлаар Гэрээний хэрэгжилтийн байдалд хөндлөнгийн үнэлгээ хийхээр тохирсон ба энэхүү хөндлөнгийн үнэлгээний багийн хийх ажлын нөхцөл шаардлагыг энэхүү ажлын даалгаварт тодорхойллоо.

### 1.2 Ажлын хамрах хүрээ:

Хөндлөнгийн үнэлгээний хүрээнд дараах болон бусад аргаар анхдагч мэдээлэл цуглуулах арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

- Гурван талт зөвлөлийн гишүүдийн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага
- Орон нутгийн албан тушаалтны ярилцлага
- Малчин өрхийн бүлгийн болон ярилцлага, уулзалт
- Компанийн ажилтнуудын ярилцлага, уулзалт
- Бусад

Хөндлөнгийн үнэлгээ хийхдээ дараах баримт бичгүүдийг судална. Үүнд:

- Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээ, түүний хавсралтууд
- Гурван талт зөвлөлийн дүрэм (2017, 2019)
- Гурван талт зөвлөлийн хурлаар гэрээний хэрэгжилтийн байдлыг хэлэлцэж үнэлсэн үнэлгээний тэмдэглэл
- Гурван талт зөвлөлийн тайлан, хамтарсан мэдээлэл бусад албан баримт бичгүүд
- Албан ёсны тоо мэдээлэл, статистик тоо баримт [Техникийн шаардлага] \*

---

<sup>1</sup> xxx

N/A

## 7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БАЙРШИЛ

---

Хөндлөнгийн үнэлгээний баг нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд ажиллана.

## 8. СТАНДАРТ ШААРДЛАГУУД

---

- Хөндлөнгийн үнэлгээ хийх аргачлал, нарийвчилсан төлөвлөгөө, хугацаа, Ковидийн нөлөөллийг тооцох
- Төслийн ахлагчийн танилцуулга, ажил мэргэжлийн дэлгэрэнгүй намтар, үр дүнгийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагыг батлах бичиг баримт
- Судалгааны багийнхны нэр, ажил мэргэжлийн дэлгэрэнгүй намтар
- Төсвийн дэлгэрэнгүй задаргаа (цалин, аялал, байр, орчуулгын зардал г.м)
- Саналыг 10 хуудсанд багтаан боловсруулна.
- Саналыг Англи, Монгол хэл дээр WORD форматаар бэлтгэж ирүүлнэ.

## 9. НИЙЛҮҮЛЭГЧИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УР ЧАДВАР

---

Энэхүү ажил үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах боловсон хүчний тоо, тавигдах шаардлага нь:

- Хөндлөнгийн үнэлгээг гүйцэтгэх баг нь 2-3 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний мэргэжилтнээс бүрдэх, социологи, микро эдийн засаг, мал аж ахуйн чиглэлээр мэргэшсэн,
- Монгол улсад болон эсвэл бусад улс оронд орон нутгийн хөгжлийн асуудал уур уурхайн нөлөөллийн асуудлаар үнэлгээ, аудитыг үндэсний хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу хэрэгжүүлсэн мэдлэг, чадвар, туршлагатай байна. Малчидтай болон Монгол улсын уул уурхайн салбарт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Үнэлгээ хийх баг нь хараат бус байдлаар мэргэжлийн өндөр ёс зүйтэйгээр холбогдох хууль стандартын хүрээнд ажиллах үүрэг хүлээнэ.

## 10. НИЙЛҮҮЛЭЛТ ХИЙХ ХУГАЦАА

---

- Хөндлөнгийн үнэлгээг Ажлын гэрээнд зурсан цагаас эхлэн 8 долоо хоногийн хугацаанд хэрэгжүүлнэ.
- Хөндлөнгийн үнэлгээний тайлангийн төслийг биечлэн танилцуулах ба тайлангийн төслийг уг танилцуулах уулзалтаас долоо хоногийн өмнө ирүүлнэ.
- Хөндлөнгийн үнэлгээний тайлан нь Англи, Монгол хэл дээр WORD хэлбэрээр байна.

Due date	Major Task	Responsible
Week 1	Хөндлөнгийн байгууллагыг сонгон гэрээ байгуулах	Contractor
Week 2	Ажлын бэлтгэл хангах	Contractor
Week 2-5	Хөндлөнгийн үнэлгээний ажил	Contractor
Week 5	Тайлан эцэслэх	Contractor
Week 6	Тайланг хүргүүлэх	Contractor
Week 7	Хэрэглэгчдэд хүлээлгэн өгөх хурал хийх	Contractor / End-User
Week 8	Ямар нэгэн санал гомдол, өөр шаардлагатай ажлыг гүйцэтгэх	Contractor

**11. ШААРДАГДАХ СУРГАЛТУУД**

---

**ОТ танилцуулга сургалт**

**ОТ аюулыг танин мэдэх сургалт**